Гадаадын иргэн, харьяатын газрын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
01/2180 дугаар албан бичгийн хоёрдугаар
хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 05 Улаанбаатар хот

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилтийн явц | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин | Төсөв (сая төг) | Төсвийн гүйцэтгэл (сая төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | 4.1.1.11.Визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. | Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем болон Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн систем хооронд мэдээлэл харилцан солилцох | 2025 - 2028 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | 320.0 | - | 20 | 140.0 | 120.0 хүлээгдэж байгаа | “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем”-ийг “Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем”-тэй холбох арга хэмжээний хүрээнд “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем (ISF)-д нэмэлт хөгжүүлэлт хийх” тендер шалгаруулалтыг 04 дүгээр сарын 24-ний өдөр зарлаж, шалгарсан аж ахуйн нэгжтэй 120,000,000 төгрөгийн төсөвт өртөг бүхий ГИХГ/20250103004/01/06-18 дугаартай гэрээг 05 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Гэрээний бүрэлдэхүүнд “Үндсэн бүртгэлийн системтэй Зорчигчийн | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | мэдээллийн урьдчилсан хяналт хийх модулийг хөгжүүлэх, интеграци хийх” тусгай шаардлагыг тусгасан ба уг системийн хөгжүүлэлт дуусаж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс байгууллагад хүлээлгэн өгснөөр хоёр системийг холбох бүх нөхцөл манай байгууллагын зүгээс бүрэн хангагдсан. https://www.tender.gov.mn/ Хөгжүүлж бэлэн болгосон системээ “Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем”-тэй холбох хугацаа Зорчигчийн мэдээллийн төвөөс шалтгаалан тодорхойгүй байна. Иймд Зорчигчийн мэдээллийн төвийн хуучин систем болох idetect системд шууд хандах эрхийг үүсгүүлэн нислэг бүрийн зорчигчийн мэдээллийг жагсаалт хэлбэрээр авч өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. mn/invitation/detail/1743570117880 2025 оны төсөв татагдсанаар гүйцэтгэгч аж ахуйн нэгжид гэрээний санхүүжилтийг олгоогүй хүлээгдэж байна. | |
| 2 | | Оршин суух үнэмлэх хэвлэх цэгийг нэмэгдүүлэх | 2025 - 2026 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын төсөв, Гадаа дын зээл, тус ламж | 500.0 | 1 | 4 | 250.0 | 170.6 | Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх 1 киоск төхөөрөмжийг Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвд байршуулж 02 дугаар сарын 20-ны өдрөөс үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн оршин суух үнэмлэх хэвлэх 1 ширхэг төхөөрөмжийг Гадаад харилцааны яаманд 2024 оны 05 дугаар сард хүлээлгэн өгч, тус яамны Ёслолын газарт дипломат албан хаагчдын оршин суух үнэмлэхийг энэ оны 06 дугаар сараас хэвлэж эхэлсэн байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Түүнчлэн Турк улсын TIKA олон улсын байгууллагаас Мишээл экспо төв дэх нэг цэгийн үйлчилгээний төвд 1 ширхэг, Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газарт 1 ширхэг төхөөрөмж тус тус байршуулан 12 дугаар сарын 05-ны өдрөөс хэвлэлтийг хийж эхэллээ. Ингэснээр гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг нийт 5 цэгт хэвлэж байна. Арга хэмжээний санхүүжилтэд 2025 онд байгууллагад төсөв батлагдаагүй бөгөөд орон нутгийн төсөв, тусламж зэрэг бусад эх үүсвэрээс шийдвэрлэсэн. | |
| 3 | | Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт тоон гарын үсэг олгох | 2025 - 2027 | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | 350.0 | - | 40 | 100.0 | цалин | Тус байгууллагад бүртгэлтэй Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газруудын мэдээллийг Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд дамжуулах FS100115_NonGovernmentHeadInfo сервисийг шинээр хөгжүүлэн уг сервисийн мэдээллийг 08 дугаар сарын 27-ны өдөр тоон гарын үсэг олгогч байгууллагуудад хүргүүлсэн. Дээрх арга хэмжээнд 2025 онд төсөв батлагдаагүй тул байгууллагаас төсөв зарцуулаагүй. https://shilendans.gov.mn/ Тоон гарын үсэг авсан байгууллагын мэдээллийг манай байгууллагаас шууд харах, системд хандах эрхгүй тул Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн 83 байгууллагад тоон гарын үсэг олгогч байгууллагаас тоон гарын үсэг авч ашиглах талаарх цахим шуудан (и-мэйл)-г 09 дүгээр сарын 23-ны өдөр хүргүүлснээр 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 30 | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | байгууллага тоон гарын үсэг авч ашиглаж байгаа талаарх баримтаа албан бичиг, албан захидал, цахим шуудангаар ирүүлсэн. | |
| Үнэлгээ: 86.6 хувь | | | | | | | | | | | | |

--oo0oo--